

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/40/НА-СТА-ТХН

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас:261885 Цахим хаяг: [tsogbayara@audit.gov.mn](mailto:tsogbayara@audit.gov.mn)  
Аудитор: Г.Өсөхжаргал  
Цахим хаяг: [usukhjargalg@audit.gov.mn](mailto:usukhjargalg@audit.gov.mn)  
Утас: 261885  
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг  
Утас:70169029 Цахим хаяг: [info@misheelodaudit.mn](mailto:info@misheelodaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3. Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, хамгааллын яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОБҮДБХЭТ	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэх төсөл
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УИХ	Улсын их хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ХЭҮ	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДТ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.31 № 06/829

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 795,193.2 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Худалдан авалтын зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулгаж шалгахад 243,227.7 мянган төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажаагүй, 109,363.5 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримт илүү шивэгдсэн.
- Үнэ төлбөргүй шилжүүлсэн 131,727.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас хассан шийдвэр болон бусад нотлох баримт ирүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 44 дүгээр зүйлийн 44.1, 44.1.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.5.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар

баталсан журмын 1 дүгээр хавсралт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтантай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний загвар”-ын 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

И-Жоб платформ болон салбарын мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэхэд 8,500,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн их өгөгдөлд тулгуурлан зарим тэтгэмж, тэтгэвэр авах хүсэлтийг цахимаар авах боломж бүрдэж, үйлчилгээний хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслөөс нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн дэмжлэгт 28,500,000.0 мянган төгрөг, жижиг зээлийн санхүүжилтэд 13,000,000.0 мянган төгрөг, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй 17 мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн зардалд 1,750,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

### **Бусад асуудал**

Тус төсөл нь 2020-2025 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, салбарын цахим шилжилтийг дэмжих чиглэлээр цогц үр дүнд хүрч, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, тэтгэмж, жижиг зээлийн дэмжлэг, сургалтаар нийт 152,475 ажилтан, 18,598 ажил олгогч, 645 бичил бизнес эрхлэгч, 4,399 иргэнийг хамруулан бодитоор дэмжсэн нь хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй хөдөлмөрийн эрэлт, үр чадварын дутмаг байдал, сул ажлын байр болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх мэдээллийн хомс байдал зэрэг хязгаарлалтыг арилгах, улмаар хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,217,544,737.40</b>	<b>4,244,483,775.74</b>
<b>31</b>	<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>3,208,632,555.77</b>	<b>4,237,429,775.74</b>
31211	Төрийн сангийн харилцах /төгрөг/	1,928,840,708.78	4,143,131,053.30
31221	Төрийн сангийн харилцах /валют/	1,279,791,846.99	94,298,722.44
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,496,000.00</b>	<b>7,054,000.00</b>
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	24,000.00	5,004,160.00
33402	ХХОАТ, НДШ- ийн авлага	-	2,049,840.00
33510	Түрээсийн барьцаа	5,472,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,416,181.63</b>	-
350401	Бичиг хэргийн материал	3,416,181.63	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,451,131.90</b>	<b>79,909,283.01</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>148,451,131.90</b>	<b>79,909,283.01</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>142,451,631.70</b>	<b>79,909,283.01</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	131,727,272.73	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,524,999.83)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	140,783,090.55	140,783,090.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,759,999.86)	(72,529,840.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,842,819.00	42,842,819.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,616,550.89)	(31,186,785.80)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,999,500.20</b>	<b>0.00</b>
39301	Програм хангамж	16,900,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,900,499.80)	-
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,365,995,869.30</b>	<b>4,324,393,058.75</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>24,000.00</b>	<b>34,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>24,000.00</b>	<b>34,000.00</b>
41362	ХХОАТ, НДШ- ийн өглөг	24,000.00	34,000.00
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,365,971,869.30</b>	<b>4,324,359,058.75</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	3,365,971,869.30	4,324,359,058.75
51210	Өмнөх үеийн үр дүн	7,194,020,736.44	3,365,971,869.30
51220	Тайлант үеийн үр дүн	(3,828,048,867.14)	958,387,189.45
<b>VIII</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,365,995,869.30</b>	<b>4,324,393,058.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,528,809,000.00	4,117,322,000.00
120009	Бусад орлого	450,000.00	1,741,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,335,675,134.68</b>	<b>3,192,496,366.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,782,094,417.24</b>	<b>1,745,476,341.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,782,094,417.24</b>	<b>1,745,476,341.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>428,574,614.21</b>	<b>368,980,000.00</b>
210101	Үндсэн цалин	428,574,614.21	368,980,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,378,436.01</b>	<b>44,510,625.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	52,378,436.01	35,119,620.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	4,199,475.00
210203	ҮОМШ-ний даатгалын шимтгэл	-	2,621,955.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,569,575.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,090,000.00</b>	<b>67,680,000.00</b>
210304	Байрны түрээс	74,090,000.00	67,680,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,262,724.22</b>	<b>7,957,073.53</b>
210401	Бичиг хэрэг	2,082,380.00	1,275,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,408,763.22	5,336,130.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	471,581.00	745,243.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>980,000.00</b>	<b>780,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	980,000.00	780,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,182,208,971.55</b>	<b>1,226,550,961.21</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж-Зөвлөх үйлчилгээ	2,182,208,971.55	1,226,550,961.21
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,599,671.25</b>	<b>29,017,681.85</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,599,671.25	27,725,681.85
210901	Бусад зардал -тендер	-	1,292,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,553,580,717.44</b>	<b>1,447,020,025.33</b>
223001	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	2,553,580,717.44	1,447,020,025.33
<b>213</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>9,193,583,865.32</b>	<b>926,566,633.08</b>
<b>2132</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>31,868,022.31</b>	<b>73,828,359.83</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	31,868,022.31	73,828,359.83
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>13,053,500,754.77</b>	<b>42,007,803.46</b>
250002	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	53,500,754.77	1,191,636.42
	Дамжуулан	13,000,000,000.00	-
<b>III</b>	<b>Хөрөнгө шилжүүлсэн</b>	<b>-</b>	<b>40,816,167.04</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(3,828,048,867.14)</b>	<b>958,387,189.45</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,528,809,000.00	4,117,332,000.00
120009	Туслах үйл ажиллагаа /тендерийн/ орлого	450,000.00	1,741,000.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>14,529,259,000.00</b>	<b>4,119,063,000.00</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,751,213,536.69</b>	<b>1,715,882,478.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,751,213,536.69</b>	<b>1,715,882,478.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,751,213,536.69</b>	<b>1,715,882,478.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>480,953,050.22</b>	<b>375,220,000.00</b>
210101	Үндсэн цалин	480,953,050.22	375,220,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>-</b>	<b>45,290,625.00</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	-	35,662,500.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	-	4,261,875.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	-	2,671,875.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	2,694,375.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,090,000.00</b>	<b>62,208,000.00</b>
210304	Байрны терээсийн хөлс	74,090,000.00	62,208,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,262,724.22</b>	<b>7,957,073.53</b>
210401	Бичиг хэрэг	2,082,380.00	1,275,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,408,763.22	5,336,130.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	471,581.00	745,243.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>980,000.00</b>	<b>780,000.00</b>
210701	Гадаад албан томилолт /арга хэмжээ /	980,000.00	780,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,182,211,932.25</b>	<b>1,224,426,779.58</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,182,211,932.25	1,224,426,779.58
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,715,830.00</b>	<b>-</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,715,830.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>11,778,045,463.31</b>	<b>2,403,180,521.89</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (V)</b>	<b>15,606,863,353.44</b>	<b>1,447,020,025.33</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,606,863,353.44</b>	<b>1,447,020,025.33</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	15,606,863,353.44	1,447,020,025.33
221001	Их засвар	13,053,282,636.00	-
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	2,553,580,717.44	1,447,020,025.33
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	<b>(15,606,863,353.44)</b>	<b>(1,447,020,025.33)</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	-	73,828,359.83
250002	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	(21,632,732.46)	(1,191,636.42)
<b>VIII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(21,632,732.46)</b>	<b>72,636,723.41</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>(3,850,450,622.59)</b>	<b>1,028,797,219.97</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,059,083,178.36	3,208,632,555.77
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,208,632,555.77	4,237,429,775.74

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	7,194,020,736.44	7,194,020,736.44
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,828,048,867.14)	(3,828,048,867.14)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,365,971,869.30	3,365,971,869.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	958,387,189.45	958,387,189.45
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	4,324,359,058.75	4,324,359,058.75

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,195,810,500.00</b>	<b>4,117,322,000.00</b>	<b>921,511,500.00</b>	<b>128.8</b>
122111	Төсвийн урсгал санхүүжилт	3,195,810,500.00	4,117,322,000.00	921,511,500.00	128.8
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,195,810,500.00	4,117,322,000.00	921,511,500.00	128.8
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,195,810,500.00</b>	<b>3,161,161,503.44</b>	<b>(34,648,996.56)</b>	<b>98.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,195,810,500.00</b>	<b>3,161,161,503.44</b>	<b>(34,648,996.56)</b>	<b>98.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,745,810,500.00</b>	<b>1,714,141,478.11</b>	<b>(31,669,021.89)</b>	<b>98.2</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>375,220,000.00</b>	<b>375,220,000.00</b>	-	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	375,220,000.00	375,220,000.00	-	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,652,500.00</b>	<b>45,290,625.00</b>	<b>(2,361,875.00)</b>	<b>95.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,663,000.00	35,662,500.00	(500.00)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,262,000.00	4,261,875.00	(125.00)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,672,000.00	2,671,875.00	(125.00)	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,876,100.00	-	(1,876,100.00)	-
210205	Эрүүл мэндийн даатгал	3,179,400.00	2,694,375.00	(485,025.00)	84.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,208,000.00</b>	<b>62,208,000.00</b>	-	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	62,208,000.00	62,208,000.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,080,000.00</b>	<b>7,957,073.53</b>	<b>(122,926.47)</b>	<b>98.5</b>
210401	Бичиг хэрэг	1,350,000.00	1,275,700.00	(74,300.00)	94.5
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	600,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,358,000.00	5,336,130.53	(21,869.47)	99.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	772,000.00	745,243.00	(26,757.00)	96.5
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,300,000.00</b>	<b>780,000.00</b>	<b>(1,520,000.00)</b>	<b>33.9</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	0.00	(1,500,000.00)	0.0

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	800,000.00	780,000.00	(20,000.00)	97.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,250,350,000.00</b>	<b>1,222,685,779.58</b>	<b>(27,664,220.42)</b>	<b>97.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,249,000,000.00	1,222,685,779.58	(26,314,220.42)	97.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,350,000.00	-	(1,350,000.00)	0.0
<b>220</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ</b>	<b>1,450,000,000.00</b>	<b>1,447,020,025.33</b>	<b>(2,979,974.67)</b>	<b>99.8</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,450,000,000.00</b>	<b>1,447,020,025.33</b>	<b>(2,979,974.67)</b>	<b>99.8</b>
222002	Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж	1,450,000,000.00	1,447,020,025.33	(2,979,974.67)	99.8
<b>152</b>	<b>Гадаад валютын зөрүүний олз</b>		<b>72,636,723.41</b>	<b>72,636,723.41</b>	
<b>152101</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз</b>		- 72,636,723.41	72,636,723.41	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		- 3,208,632,555.77	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		- 4,237,429,775.74	-	-
	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>0</b>	<b>100</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	0	100

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа**

Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан хөнгөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээний дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл нь 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжихээр батлагдсан бөгөөд 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна.

Санхүүжилтийн хэлэлцээрийг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр УИХ-аас соёрхон баталжээ.

Тус төсөл нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018-2022 онд хэрэгжүүлсэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн дараагийн шатны төсөл юм.

Төслийн зорилго нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй хөдөлмөрийн эрэлт, ур чадварын дутмаг байдал, сул ажлын байр болон хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх мэдээллийн хомс байдал зэрэг хязгаарлалтыг арилгах, улмаар хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

**Бүрэлдэхүүн хэсэг 1. “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх”:** Үйлчлүүлэгч төвтэй төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжсэнээр мэдээллийн хомс байдал болон хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдал хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй ажил хайхад учирдаг хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн.

**Бүрэлдэхүүн хэсэг 2. “Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх”:** Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлыг сайжруулахад чиглэсэн.

**Бүрэлдэхүүн хэсэг 3. “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон төслийн менежментийг сайжруулах”:** хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар байгууллагын болон хувь хэрэглэгчдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд үндэслэн зөв шийдвэр гаргахад туслах, хяналт-шинжилгээ үнэлгээ ба төслийн удирдлагыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн.

**Бүрэлдэхүүн хэсэг 4. “КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан албан журмын даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх”:**

Ковид-19 цар тахлын үед албан журмын даатгуулагч, ажилтнууд болон тэдний ажил олгогчдод түр хугацаанд тэтгэмж олгоход чиглэсэн.

Төслийн 1-3 дахь бүрэлдэхүүн хэсгүүд нь хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг сайжруулахад чиглэсэн бол бүрэлдэхүүн хэсэг 4 нь КОВИД-19 цар тахлын үед нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан ажилтнуудад богино хугацаанд тэтгэмж олгоход чиглэсэн.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр

санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам”;

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ТХН нь төслийн бүх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд, үүнд чадавх бэхжүүлэх сургалт, судалгаа шинжилгээ, хяналтын ажлуудыг хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд мөн төслийн хөгжлийн зорилт, дунд хугацааны үзүүлэлтүүдийн үр дүнг хянаж, хяналт шинжилгээ, санхүү, худалдан авах ажиллагаа, байгаль орчны удирдлагын хүрээ ба үр дүнгийн хүрээний тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж, ЗГ-ын гадаад зээл, тусламжийн төслүүдийн цахим мэдээллийн системд мэдээлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 958.397.2 мянган төгрөгөөр буюу 128.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,208,632.6	4,237,429.8	1,028.8
Авлага	5,496.0	7,054.0	1,558.0
Бараа материал	3,416.2	-	(3,416.2)
Үндсэн хөрөнгө	148,451.1	79,909.3	(62,542.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,365,995.9</b>	<b>4,324,393.1</b>	<b>958,397.2</b>
Өр төлбөр	24.0	34.0	10.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,365,971.9	4,324,359.1	958,387.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,365,995.9</b>	<b>4,324,393.1</b>	<b>958,397.2</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,028.8 мянган төгрөгөөр өссөн нь зээл тусламжийн орлогын үлдэгдэл 955.0 мянган төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгээс 73.8 мянган төгрөг тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 1,558.0 мянган төгрөгөөр өссөн нь түрээсийн барьцаа 5,472.0 мянган төгрөгөөр хорогдож ХХОАТ-ын авлага 2,049.8 мянган төгрөг, ажиллагчдаас авах авлага 4,980.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.
- Бараа материал дансны үлдэгдэл 3,416.2 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийг төслийн үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,542.3 мянган төгрөгөөр буурсан нь 131,727.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл болон 16,900.0 мянган төгрөгийн программ хангамжийг данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардлыг 27,725.7 мянган төгрөгөөр тайлагнасантай холбоотой байна.
- Өр төлбөр 10.0 мянган төгрөгөөр өссөн нь цалин хөлсний татварын тооцоогоор өссөнөөс шалтгаалсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо 958,397.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээр өссөн байна.

Тус төслийн санхүүгийн тайланд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 16,900.0 мянган төгрөгийн программ бүртгэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг гадаад эх үүсвэрээс 11,992,020.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 11,992,020.0 мянган төгрөгөөр өөрчлөлтгүй баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 8,796,209.5 мянган төгрөгөөр бууруулж төсвийн тодотгол хийж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг 3,195,810.5 мянган төгрөгөөр гадаад зээлээр санхүүжүүлэхээр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн эх үүсвэрээс 4,117,322.0 мянган төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,161,161.5 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлыг 34,649.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээ	3,195,810.5	3,161,161.5	34,649.0	98.9
1	80104 Гадаадын зээлээр хэрэгжүүлэх ажил	3,195,810.5	3,161,161.5	34,649.0	98.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тус байгууллагын ажилчид нь Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын дагуу хөдөлмөрийн гэрээнд тулгуурлан цалин хөлсийг тооцдог тул орон тооны цомхотголд хамаарахгүй.
- Хөдөлмөрийн гэрээнд унаа хоолны хөнгөлөлт тусгадаггүй тул унаа хоолны хөнгөлөлтийн зардал байхгүй.
- Тайлант онд АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулах Дэлхийн банкны 2025 оны хаврын чуулга уулзалт, Швейцарын Холбооны Улсын Женев хотод зохион байгуулах “Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн 113 дугаар хурал, уулзалт”, Бүгд Найрамдах Аргентин Улсын төсвийн бодлого, зохицуулалт болон холбогдох хууль, эрх зүйн орчинтой танилцах, санал солилцох, туршлага судлах 3 удаагийн 490,706.9 мянган төгрөгийн гадаад албан томилолтын зардлыг бусдаар гүйцэтгүүлэх зардлын ангиллаас зарцуулсан байна.
- Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд тус тус зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй.

### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 34.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Бүрэлдэхүүн хэсэг/ Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгж илтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв (2025)	Зарцуулсан төсөв (2025)
<b>Бүрэлдэхүүн хэсэг 1. Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх</b>						
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа болон ажил зуучлалын мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах дотоодын зөвлөх компани ажиллуулах	2024 - 2025	Ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлалын сургалтын хөтөлбөр бэлтгэн сургалт хийснээр ажилтнуудын мэдлэг, ур чадвар сайжирсан байна.	100.0	68,000.0	68,000.0
2	ХЭҮ-ний ажилтнуудыг чадавхжуулах шинэчлэгдэн боловсруулсан сургалтын материалыг видео болгон хөрвүүлэх	2024 - 2025	Хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын материалыг видео хэлбэрт хөрвүүлснээр ажилтнууд цахимаар суралцах боломж бүрдсэн байна.	100.0	147,620.0	147,620.0
3	Хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, холбогдох журмын талаарх онлайн сургалтын модуль боловсруулах	2024 - 2025	Онлайн сургалтын модуль, видео хичээлийг боловсруулснаар салбарын ажилтнууд цахимаар суралцах боломж бүрдсэн байна.	90.0	40,000.0	36,000.0
<b>Бүрэлдэхүүн хэсэг 2. Хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг хөтөлбөрүүдийг сонгож, турших</b>						

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Их өгөгдөлд суурилсан мэдээллийн системд зориулсан сервер, хадгалах төхөөрөмж, сүлжээний төхөөрөмж болон програм хангамжийн лицензүүд (Үүлэн дэд бүтэц байгуулах) худалдан авах	2025	Салбарын их өгөгдлийн мэдээллийг нэгтгэх, хадгалах, үр дүнтэй боловсруулах дэвшилтэт системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.	25.6	5,361,312.9	1,372,262.6
5	Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх сургагч багш нарыг бэлтгэх, сургалтын агуулгыг сайжруулах	2024 - 2025	Бичил бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадвар сайжирсан байна.	100.0	18,450.0	18,450.0
6	И-Жоб хэрэглэгчдэд нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмжийн баталгаат хугацааны төлбөр	2024 - 2025	Баталгааг сжуллаж, гэрээг хаасан байна.	100.0	68,465.9	68,465.9
<b>Бүрэлдэхүүн хэсэг 3. Хөдөлмөрийн зах зээлийн мониторинг, дүн шинжилгээг сайжруулах, төслийн удирдлага</b>						
7	Тэтгэврийн даатгалын тогтолцооны актуар үнэлгээ хийх олон улсын зөвлөх ажиллуулах	2025	Тэтгэврийн шинэчлэлийн тооцоололд ашиглах боломж бүрдэж, хуулийн шинэчлэлд дэмжлэг үзүүлсэн байна.	25.7	133,200.0	34,206.6
8	Нийгмийн даатгалын системийн шинэчлэлийн холбогдох судалгаа хийж, тооцоолол боловсруулах дотоодын зөвлөх ажиллуулах	2025	Тэтгэврийн шинэчлэлийн актуар үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлсэн байна.	20.0	35,000.0	7,000.0
9	Олон нийтэд хүргэх мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, цахимаар түгээх	2025	Төслийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт дээшилсэн байна.	100.0	30,790.0	30,790.0
10	Төслийн мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зөвлөхийн бус үйлчилгээ	2025	Төслийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, оролцоо нэмэгдсэн байна.	100.0	96,200.0	96,200.0
11	Ур чадварын шинэлэг хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээний дизайн, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үндэсний зөвлөхийг гэрээгээр ажиллуулах	2024 - 2025	Үнэлгээний арга зүй, дизайныг бусад төсөл хөтөлбөр арга хэмжээний үр нөлөөг үнэлэхэд ашиглах боломжтой болно.	100.0	65,960.0	65,960.0
12	Ур чадварын шинэлэг хөтөлбөрийн суурь болон төгсгөлийн судалгааны мэдээлэл цуглуулалт, мэдээллийн дүн шинжилгээ, тайлан зэргийг багтаасан үнэлгээ хийх зөвлөх байгууллагыг гэрээгээр ажиллуулах	2024 - 2025	Цаашид судалгаанд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг илүү үр дүнтэй төлөвлөх, хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ.	100.0	30,000.0	30,000.0

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийх, бодлогын стратеги боловсруулах зөвлөх байгууллагыг ажиллуулах. Бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөөний тайланг түгээх семинар зохион байгуулах	2024 - 2025	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг илүү нарийвчлан тодорхойлох боломж бүрдсэн байна.	100.0	38,700.0	38,700.0
14	"eJob" платформд шинээр нэмж оруулсан ажил мэргэжлүүдийн нарийвчилсан ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг боловсруулахад ГБХНХЯ-д дэмжлэг үзүүлэх зөвлөх компанийг гэрээгээр ажиллуулах	2024 - 2025	И-Жоб системд ажлын байрны нарийвчилсан мэдээллийг бүрдүүлж, ажил зуучлалын үйл ажиллагаанд ашиглах боломж нэмэгдсэн байна.	100.0	69,300.0	69,300.0
15	ҮАМАТ-08-д шинэ ажил, мэргэжлүүдийг нэмэх, өөрчлөх шаардлагатай ажил мэргэжлүүдийг шинэчлэх үндэсний зөвлөхүүдийг гэрээгээр ажиллуулах Т.Энхтуяа.	2024 - 2025	Ажил мэргэжлийн ангилал салбарын бодит бүтцэд нийцэж, тоон мэдээлэл, ажил зуучлал сайжирсан байна.	100.0	36,000.0	36,000.0
16	Бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ХХҮЕГ-т дэмжлэг үзүүлэх дотоодын зөвлөхийг гэрээгээр ажиллуулах	2024 - 2025	Зээл олгосноор бичил бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавх дээшилсэн байна.	100.0	5,600.0	5,600.0
17	Төслийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэхэд ГБХНХЯ/ТХН-д дэмжлэг үзүүлэх зөвлөхийг гэрээгээр ажиллуулах	2024 - 2025	Төслийн олон нийтэд хүрэх мэдээллийн чанар, хамрах хүрээ сайжирсан байна.	100.0	27,000.0	27,000.0
<b>Нийт</b>					<b>6,271,598.8</b>	<b>2,151,555.1</b>

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээний санхүүжилт хасагдсантай холбоотойгоор гүйцэтгэл бага байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 28 бараа, ажил, зөвлөх үйлчилгээнд нийт 7,624,800.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 5,709,200.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5,656,902.9 мянган төгрөгийн дүн бүхий 5 гэрээ байгуулж, 2,151,555.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Эдгээр ажлуудаас 3 гэрээт ажил дуусаж, 2 зөвлөх үйлчилгээний ажил гэрээний дагуу үргэлжлэн хэрэгжиж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төслийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулах, татварын хөнгөлөлтийг үнэн зөв тооцоолох, холбогдох тушаал шийдвэргүйгээр хөрөнгө данснаас хасахгүй байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мишээл-Од Аудит” ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, үе шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 26/07 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 18,389,175.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 183,981.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 614,621.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 434,936.6 мянган төгрөгийн зарлагын 13 гүйлгээг мэдээлээгүй, 179,685.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус тус хугацаа хоцорч байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитыг Сангийн яамны зөвшөөрөл хойшлогдсоноос шалтгаалан завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 5,858,003.2 мянган төгрөгийн 1 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,858,003.2	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5,858,003.2</b>	-	-	-

Өмнөх оны аудитаар шилэн дансанд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилгахаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Уг зөрчлийг гаргасан хариуцсан ажилтнууд ажлаас чөлөөлөгдсөн тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх боломжгүй болж, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг одоогийн удирдлагуудад хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 805,123.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардал 27,725.7 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн тайлант хугацааны элэгдлийн зардлыг 80,085.4 мянган төгрөгөөр тусгаж, 52,359.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлан болон үр дүнгийн тайланд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн 420,510.6 мянган төгрөгийн зардлуудыг зардал тус бүрээр тайлагнаагүй бөөн дүнгээр тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эхний үлдэгдэл 332,253.2 мянган төгрөгийг нэмэгдсэн үндсэн хөрөнгө мөрөнд алдаатай тайлагнасан;

Эдгээр алдаанууд нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 795,193.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 4,971.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 305,783.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 484,438.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 795,193.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 611,301.5 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 03/4651 тоот шийдвэрээр 1 ажилтны цалинг 4,520.0 мянган төгрөгөөр тогтоосон байхад 5,040.0 мянган төгрөгөөр тооцож олгосноос 4,971.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

- Монгол Улсын Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 8 төлөөлөгчдийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Аргентин Улс, Бүгд Найрамдах Чили Улсын төсвийн бодлого зохицуулалт болон

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

холбогдох хууль, эрх зүйн орчинтой танилцах, санал солилцох, туршлага судлах ажлын айлчлалын гадаад албан томилолтын зардалд 189,380.3 мянган төгрөгийг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын баталсан төсвийн дагуу төслийн үндсэн үйл ажиллагааны данснаас зарцуулсан байна. Энэхүү айлчлалын үр дүн тодорхойгүй, төлөөлөгчид ямар ач холбогдолтой ажил хэрэгжүүлсэн талаар тодорхой баримт байхгүй, баримтад хавсаргасан тайлан байхгүй, уг төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, төслийн зорилгод нийцээгүй томилолтын зардал гаргаж, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

- Монгол Улсын Их Хурлын гишүүд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн УИХ-03/4617 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хурлын даргад 2025 оны 04 дүгээр сарын 18-наас эхлэн 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдсан "Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн хаврын уулзалт"-д оролцож санхүүгийн тогтвортой хөгжлийн чиглэлээр туршлага судлах чөлөөг хүсч, томилолттой холбоотой зардлыг гишүүд өөрсдөө гаргахаар хүсэлт тавьсны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 178 тоот захирамжаар УИХ-ын 5 гишүүдийг өөрсдийн зардлаар чуулга уулзалтад оролцохыг зөвшөөрсөн боловч тус 5 гишүүн болон 4 сэтгүүлч, хэвлэлийн төлөөлөгчдийн зардлыг тус төслийн хөрөнгөөс гаргасан байна. Төлөөлөгчид уулзалтад оролцсоноор төсөлд ямар үр дүн гарсан, хэрэгжүүлсэн ажил нь тодорхойгүй, төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, зорилгод нийцээгүй гадаад албан томилолтын зардалд нийт 254,791.0 мянган төгрөгийг зарцуулснаас 5 хүн бизнес ангиллын нислэгээр зорчиж 116,402.8 мянган төгрөгийн зардал гаргаж төслийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Гишүүний цалин, нэмэгдэл, албан томилолт, бичиг хэргийн болон үйл ажиллагааны бусад зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Гишүүнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 44.1.5-д "Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Засгийн газар, түүний байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний зардлаар гадаадад зорчих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-т "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" 46.5.3-т "зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, төслийн зорилгод нийцээгүй томилолтын зардал гаргаж, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Худалдан авалтын зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулгаж шалгахад 6 харилцагчийн 243,227.7 мянган төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажаагүй, 12 харилцагчаас 109,363.5 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү шивэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын гүйлгээг анхан шатны төлбөрийн баримтаар бүрэн баримтжуулж ажиллах

### **2. Цалин хөлсний данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 1 ажилтны татварын хөнгөлөлтийг тооцоогүйгээс 120.0 мянган төгрөгийн татварыг илүү суутгасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу татварын хөнгөлөлтийг үнэн зөв тооцоолж тайлагнах

### **3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үнэ төлбөргүй шилжүүлсэн 131,727.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас хассан шийдвэр болон бусад нотлох баримтыг аудитын явцад ирүүлээгүй.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын 1 дүгээр хавсралт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтантай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний загвар”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Ажилтан нь Захиалагчаас хариуцуулж өгсөн бүтээгдэхүүн, машин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мөнгөн болоод биет эд зүйлс /үнэт цаас/, тооцоо, мэдээ, санхүүгийн баримтын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй эзэмших, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй бусад шилжүүлэхгүй байх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн дагуу холбогдох тушаал, шийдвэргүйгээр хөрөнгийг данснаас хасаж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардлын үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн тайлант хугацааны элэгдлийн зардлыг илүү тайлагнасан.	1	52,359.7			1	52,359.7	1	52,359.7				
2	Мөнгөн гүйлгээний тайлан болон үр дүнгийн тайланд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг зардал тус бүрээр тайлагнаагүй бөөн дүнгээр тайлагнасан	1	420,510.6			1	420,510.6	1	420,510.6				
3	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эхний үлдэгдлийг нэмэгдсэн үндсэн хөрөнгө мөрөнд алдаатай тайлагнасан	1	332,253.2			1	332,253.2	1	332,253.2				
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>805,123.5</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>3</b>	<b>805,123.5</b>	<b>3</b>	<b>805,123.5</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сангийн сайдын шийдвэрээс зөрүүтэйгээр 1 ажилтны цалинг 4,971.6 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	4,971.6	1	4,971.6						
2	1.Монгол Улсын Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 8 төлөөлөгчдийн Бүгд Найрамдах Аргентин Улс, Бүгд Найрамдах Чили Улсын төсвийн бодлого зохицуулалт болон холбогдох хууль, эрх зүйн орчинтой танилцах, санал солилцох, туршлага судлах ажлын айлчлалын гадаад албан томилолтын зардалд 189,380.3 мянган төгрөгийг төслийн хөрөнгөөс зарцуулсан ба тус айлчлалыг хийх холбогдох дээд газрын шийдвэр байхгүй, айлчлалын үр дүн тодорхойгүй, төлөөлөгчид ямар ач холбогдолтой ажил хэрэгжүүлсэн талаар тодорхой баримт байхгүй, баримтад хавсаргасан тайлан байхгүй, төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, төслийн зорилгод нийцээгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан. 2. АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдсан "Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн хаврын уулзалт"-д УИХ-ын 5 гишүүн болон 4 сэтгүүлч, хэвлэлийн төлөөлөгчдийн зардлыг тус төслийн хөрөнгөөс гаргасан нь төсөлд ямар үр дүн гаргасан, хэрэгжүүлсэн ажил нь тодорхойгүй, төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, зорилгод нийцээгүй, 5 хүн бизнес ангиллын нислэгээр зорчиж 116,402.8 мянган төгрөгийн зардал гаргасан.	1	305,783.1			1	305,783.1				
3	Худалдан авалтын зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримттай тулгаж шалгахад 243,227.7 мянган төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажаагүй, 109,363.5 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү шивэгдсэн.	1	352,591.2					1	352,591.2		
4	Ажилтны татварын хөнгөлөлтийг хуулийн дагуу тооцоогүйгээс татварыг илүү суутгасан.	1	120.0					1	120.0		
5	Үнэ төлбөргүй шилжүүлсэн тээврийн хэрэгслийг данснаас хассан шийдвэр болон бусад нотлох баримтыг ирүүлээгүй.	1	131,727.3					1	131,727.3		
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>795,193.2</b>	<b>1</b>	<b>4,971.6</b>	<b>1</b>	<b>305,783.1</b>	<b>3</b>	<b>484,438.5</b>	<b>0</b>	<b>0.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13 удаагийн 434,936.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 1 удаагийн 179,685.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг хугацаа хоцорч байршуулж, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	1	614,621.6	1	614,621.6				
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>614,621.6</b>	<b>1</b>	<b>614,621.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 210/АД150169

Улаанбаатар хот

САГ - 2026 /40/НА - СТА - ТХН

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 03/4651 тоот шийдвэрээр 1 ажилтны цалинг 4,520,000.00 /дөрвөн сая таван зуун хорин мянган/ төгрөгөөр тогтоосон байхад 5,040,000.00 /таван сая дөчин мянган/ төгрөгөөр тооцож олгосноос 4,971,600.00 /дөрвөн сая есөн зуун далан нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1. “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү тооцож олгосон 4,971,600.00 /дөрвөн сая есөн зуун далан нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийг худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Ц.Юмжирдуламаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Х.Асыл/-т хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Т.ОДОНЧИМЭГ

9006100  
ATA16007  
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0325 SAG-9.Docx

1526200301



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1127/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/40/НА-СТА-ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 8 төлөөлөгчдийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Аргентин Улс, Бүгд Найрамдах Чили Улсын төсвийн бодлого зохицуулалт болон холбогдох хууль, эрх зүйн орчинтой танилцах, санал солилцох, туршлага судлах ажлын айлчлалын гадаад албан томилолтын зардалд нийт 189,380,260.00 /нэг зуун наян есөн сая гурван зуун наян мянга хоёр зуун жар/ төгрөгийг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын баталсан төсвийн дагуу төслийн үндсэн үйл ажиллагааны данснаас зарцуулсан байна. Энэхүү айлчлалыг хийх холбогдох дээд газрын шийдвэр байхгүй, айлчлалын үр дүн тодорхойгүй, төлөөлөгчид ямар ач холбогдолтой ажил хэрэгжүүлсэн талаар тодорхой баримт байхгүй, баримтад хавсаргасан тайлан байхгүй, төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, зорилгод нийцээгүй томилолтын зардал гаргаж, зээлийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.
2. Монгол Улсын Их Хурлын гишүүд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн УИХ-03/4617 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хурлын даргад 2025 оны 04 дүгээр сарын 18-наас эхлэн 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдсан "Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн хаврын уулзалт"-д оролцож санхүүгийн тогтвортой хөгжлийн чиглэлээр туршлага судлах чөлөөг хүсэж, томилолттой холбоотой зардлыг гишүүд өөрсдөө гаргахаар хүсэлт тавьсны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны 178 тоот захирамжаар УИХ-ын 5 гишүүдийг өөрсдийн зардлаар чуулга уулзалтад оролцохыг зөвшөөрсөн боловч тус 5 гишүүн болон 4 сэтгүүлч, хэвлэлийн төлөөлөгчдийн зардлыг тус төслийн хөрөнгөөс гаргасан байна. Төлөөлөгчид уулзалтад оролцсоноор төсөлд ямар үр дүн гарсан, хэрэгжүүлсэн ажил нь тодорхойгүй, төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, зорилгод нийцээгүй гадаад албан томилолтын зардалд нийт 254,791,000.00 /хоёр зуун тавин дөрвөн сая долоон зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийг зарцуулснаас 5 хүн бизнес ангиллын нислэгээр зорчиж 116,402,800.00 /нэг зуун арван зургаан сая дөрвөн зуун хоёр мянга найман зуун/ төгрөгийн гаргаж төслийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Гишүүний цалин, нэмэгдэл, албан томилолт, бичиг хэргийн болон үйл ажиллагааны бусад зардлыг Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Гишүүнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 44.1.5-д "Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Засгийн газар, түүний байгууллага түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний зардлаар гадаадад зорчих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-т "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" 46.5.3-т "зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-26.Docx

1526181517

зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, зорилгод нийцээгүй гадаад албан томилолтын зардал гаргаж, зээлийн хөрөнгийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Х.Асыл/, төслийн санхүүгийн ажилтан /Р.Баярмаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1128/А0150169

Улаанбаатар хот

САГ -2026/40/ИА-СТА-ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 434,936,646.00 /дөрвөн зуун гучин дөрвөн сая есөн зуун гучин зургаан мянга зургаан зуун дөчин зургаан/ төгрөгийн зарлагын 13 гүйлгээг мэдээлээгүй, 179,685,000.00 /нэг зуун далан есөн сая зургаан зуун наян таван мянган/ төгрөгийн орлогын 1 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус тус хугацаа хоцорч мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч /Х.Асыл/, төслийн санхүүгийн ажилтан /Р.Баярмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 109 хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-26.Docx

1526181519